

УДК 930.85+82(517.3)

МОНГОЛЫН ЭРТНИЙ УРАН ЗОХИОЛ ДАХЬ ЗАМ ЯВАХЫН УРАН ЗОХИОЛЫН ТУХАЙД ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ

Husile

МУИС-ын докторант, МонГУ, Улаанбаатар, Монгол Улс

E-mail: husile08@126.com

Товчлол

Зам явахын уран зохиол нь хаад ихэс дээдэс, номын мэргэд, түүхэн хүмүүс ихэвчлэн аян замд явсан сонин сайхан үйл явдал, аяллын тэмдэглэлийг бодит баримт мэдээлэл, уран сайхны аргыг хослуулан өгүүлдэг бөгөөд эртний уламжлал нь зөвхөн монгол хэлээр бус, төвөд хэлээр ч ихэд дэлгэрч байсан. Түүнчлэн монголын уран зохиолд энэ төрлийн бүтээлүүд нь шашны үйл ажиллагаа, нийгмийн харилцаа, соёлын солилцоог илтгэн харуулдаг. Энэхүү илтгэлээр Монголын зам явахын уран зохиолын уран сайхны онцлог, түүхэн хөгжлийн талаар судалгааны үндэслэлтэйгээр дэлгэрэнгүй өгүүлэх болно. Зам явахын уран зохиол нь баримтат ба уран сайхны аргыг хослуулж, монгол хүний ертөнцийг үзэх үзэл, сэтгэлийн хөдөлгөөн, мөн бусыг танин мэдэх мэдрэмжийг уран дүрслэлээр баяжуулдаг. Монголын зам явахын уран зохиолын уран сайхны онцлог нь гол төлөв яруу найраглаг байдлаар илэрхийлэгддэг бөгөөд энэ нь уншигчдыг тухайн аяллын уур амьсгалд оруулж, аяллын мэдрэмжийг амилуулдаг. Монголын Зам явахын уран зохиол нь дан ганц газар зүйн зураглал биш, харин тухайн үеийн монгол хүний сэтгэл зүй, нийгмийн харилцааг илэрхийлэх хүчирхэг арга хэрэгсэл болж өгдөг.

Түлхүүр үг

Монголын эртний уран зохиол, зам явахын уран зохиол, Агваандоржиевийн аян замын зохиол, шашин соёлын солилцоо Монголд.

UDC 930.85+82(517.3)

A BRIEF DISCUSSION ON TRAVEL GENRE IN ANCIENT MONGOLIAN LITERATURE

Husile

PhD student at National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

E-mail: husile08@126.com

Annotation

Travel literature often combines factual accounts and artistic expression to narrate the fascinating events and experiences of kings, nobles, scholars, and historical figures during their journeys. This ancient tradition was not only widespread in the Mongolian language but also extensively developed in Tibetan. Additionally, such works in Mongolian literature reflect religious practices, social interactions, and cultural exchanges. This paper will discuss in detail the artistic characteristics and historical development of Mongolian travel literature based on research. Travel literature combines documentary and artistic methods, enriching the worldview, emotions, and feelings of Mongolian people with artistic depictions. The artistic characteristics of Mongolian travel literature are mainly expressed in poetic form, which brings readers into the atmosphere of the journey and brings the feeling of the journey to life. Mongolian travel literature is not only a geographical map, but also a powerful means of expressing the psychology and social relations of Mongolian people at that time.

Key words

Ancient Mongolian literature, travel literature, Agvaandorjiev's travel writing, religious and cultural exchange in Mongolia.

НЭГ. ЗАМ ЯВАХЫН УРАН ЗОХИОЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Монголын уран зохиол дахь баримтат уран сайхны зохиолын нэгэн төрөл болох Зам явахын уран зохиол нь эртний үлгэр домгийн зүйлсээс улбаалан аман бичгийн уран зохиолын харилцаа холбоон дунд өөрийн өвөрмөц бүтэц хэлбэрийг хадгалсаар үе үеийн шашин, соёл, түүх, уран зохиолын зүтгэлтнүүдийн зохиол бүтээлээр тасралтгүй баяжин монгол, төвөд хэлээр ихэд дэлгэрсэн нэгэн өвөрмөц төрөл юм (Монгол зохиолчдын, 1967; Монголын орчин үеийн, 1985; Хүрэлбаатар, 1992; Сүглэгмаа, 2005).

“Зам явахын уран зохиол” гэсэн нэр томьёог хамгийн анх нэрт төвдөч эрдэмтэн Л. Хүрэлбаатар багш Монголын төвөд хэлт уран зохиолын эмхтгэл “Алтан хүрдэн” номдоо тусгай бүлэг болгон оруулж хэвлэсэн байдаг (1992). Нөгөө талаар зам явахын уран зохиол нь Замын тэмдэглэл гэсэн нэр томьёогоор өнөө цагт сэтгүүл зүйн ч судлагдахуун болсоор ирсэн билээ.

“Зам явахын уран зохиол” гэсэн нэр томьёо нь “замын тэмдэглэл”-тэй ижил утгаар оршиж байна. Замын тэмдэглэлийг орос хэлэнд “путевые заметки”, англиар “travel notes”, хятад хэлэнд “ёу жи” (游记文学), төвөд хэлэнд “ཡལ་ཤར་ཟིན་ཐོ་རྩིས་རིག” гэж томьёолдог.

Зам явахын уран зохиол гэдэг нь зохиолч өөрийн нутаг орноор болон харь оронд зорчин явахдаа тухайн газрынхаа шинэ сонин зүйл, тэдгээр орны хөгжил цэцэглэлт, ард түмний аж байдал, зан заншил, түүх соёл, тэрхүү замын туршид тохиолдсон сонин сайхан үйл явдал зэрэг өвөрмөц зүйлийг өөртөө болон өөр бусдад зориулан танин мэдүүлэх зорилгоор түүхэн баримт болон уран сайхны арга хэрэглүүрийг хослуулан бичдэг баримтат уран сайхны зохиолын нэгэн өвөрмөц хэлбэр юм (Дамдинсүрэн, 1998; Цендина, 2022). Ийм учраас замын тэмдэглэлийг шинэ улс орон далай тэнгис газар нутгийг нээгч зүйл гэж нэрлэдэг ч ёс бий (Норовсүрэн, 1994; 1996).

Зам явахын уран зохиол нь зохиогчоос өргөн дэлгэр мэдлэг, ажигч гярхай чанар асар их цаг хугацаа хүч хөдөлмөр шаарддаг, мэдээлийн багтаамж сайтай, танин мэдэхүйн ач холбогдолтой нэгэн сонирхолтой бичлэгийн төрөл юм.

Хятадын судлалд “эртний зам явхын уран зохиол нь онцгой нэгэн хэлбэрийн түүхэн газар зүйгийн сурвалж бичиг, тэр нь зохиогчоос зам явах зуурын үзэж харсан, сонсонноо бичсэн тэмдэглэл болно”; “зам явахын уран зохиол нь баримтат уран зохиол, түүний онцлог нь үнэн бодит чанар болон сонин мэдээний чанар хослосон байдаг”; “зам явахын уран зохиол нь онцгой нэгэн бичгийн хэлбэрээр хятадын эртний соёлын хүрээнд онцгой байр суурьтай” гэж (崔冰洋, 2015) тэмдэглэсэн байдаг.

Хураангуйлбал, зам явхын уран зохиол нь аялал хийх явцыг бичсэн нэгэн зүйлийн бичлэгийн хэлбэр, үзсэн харсаннаа тэмдэглэсэн нэгэн зүйлийн уран зохиол мөн.

Хятадын эртний зохиолд “MU TIANZI JOURNEY” (穆天子传), “Feng shan yi тэмдэглэл” (封禅仪记), “Ru shu тэмдэглэл” (入蜀记) гэх зохиолууд нь бөгд үнэн бодитайгаар аялалын зам зуурын хэрэг явдлыг тэмдэглэн бичиж, уран сайхны онцлогоор бичсэн байдаг (Zheng, 2011; Cui Bingyang, 2018).

Хятадын эртний зохиолын зам явахын уран зохиол нь нийтийн он тооллоос өмнөх 202 оноос эхлэн тасралтгүй хөгжиж ирсэн түүхтэй. Тэр үед бичигдсэн “Yu gong” (禹贡), “Shan hai jing” (山海经) гэсэн төлөөлөл болсон сурвалж бичиг нь түүхэн газар зүйгийн талыг тооцон бичсэн аялалын тэмдэглэлийн бүтээл болно. Энэ үеийн зам явхын уран зохиол нь улс төрийн бодлого буюу нийгмийн үйлчилгээний зорилгоор бичигдсэн байдаг, гэхдээ энэ үеэс эхлэн зам явхын уран зохиолын бүтэц алгуур аажмаар бүрэлдэж эхэлсэн байна.

Энэ зохиол нь Баруун Жөүгийн үе, даруй нийтийн он тооллын 281 оны үеэс гаралтай, Хятадын зам явхын уран зохиолын уламжлалд хамгийн эртний зохиол болно.

Жөү Мү хааны энэ аялал нь Хятадын бичиг үсэгт тэмдэглэгдсэн хамгийн эртний аялалын тэмдэглэл буюу зам явхын уран зохиол болно. Энэ бүтээл нь баримтат зам явхын уран зохиол болсны хувьд, зохиогчоос нь янз бүрийн уран сайхны дүрслэх аргийг хэрэглэж, зохиолын дүр болон байгалийн үзэмжийг улам амьдлаг болгож, уран бүтээлээ улам нэг алхам хөгжүүлсэн байна.

ХОЁР. МОНГОЛЫН ЭРТНИЙ УРАН ЗОХИОЛ ДАХЬ ЗАМ ЯВАХЫН УРАН ЗОХИОЛ

Монголын эртний бичгийн уран зохиолд Цахар гэвш Лувсанчүлтэмийн “Богд Зонховын намтар”, Хөх нуурын Ишбалжирын “Сүмбэ хамбын шастир”, анхдугаар богд Өндөр гэгээн Занабазарын намтар, ноён хутагт Данзаравжаа “V ноён гэгээнтний цэдгийн товч хураангуй” зэрэг олон бүтээлд цастын орон хийгээд монгол орны хурал номын газар шашин сүм хийд хошуу нутгаар зорин явж хэнтэй уулзаж юу үзэж харж хэрхэн явсан тухайгаа өгүүлсэн зүйлс элбэг байгаа нь өдгөө цагийн зам явахын уран зохиолын шинжийг агуулж байна.

Үүнээс гадна ойрадын уран зохиолын амьд хэлний баримт хэрэглэгдхүүн болж байгаа нэгэн аялалын тэмдэглэл буюу зам явахын уран зохиол байдаг (Бадмаев, 1973). Тэр нь даруй Бага Дөрвөд нутгийн Баазр ламын төвөдийн орноор аялан явсан түүх болно. Тэр нь хэл шинжлэл, уран зохиолын дурсгалын онцлогийг бүгд хадгалж байгаа билээ, тодруулан хэлхэд Болжин Халимагуудын хэл яриа буюу утга зохиолын хэл, үгсийн сангын байдал тэргүүтэн тэр хэвээрээ байгаа тул эртний Зүнгар улсын үеийн буюу Ижил Мөрөнд ирж сууришиж байх үеийн халимагуудын хэлний баримтатай харьцуулан судлахд судлагдхуун болж байна.

Баазр багш нь монгол гаралтай халимаг лам болно (Омакаева, 2013). Тэр бээр 1841 онд Халимагийн Бага Дөрвөдт төржээ. Түүний энэхүү аялал нь 1891 онд Халимагийн тал нутгаас өөрийн хоёр нөхрийн хамт Төвөдөд Далай ламд мөргөхөөр очиж, бүтэн гурван жил үргэлжилсэн байна. Түүний тэмдэглэлд зам зуурын сонин содон зүйлийг хаяа нэг бичсэн бөгөөд тааралдсан суурин газрын гадаад байдал, оршин суугчид, худалдаа наймаа, үйлдвэр гар урлал, эдийн засгийн болон нийгмийн харилцааны талаар ямар ч мөр байхгүй. Яг ламын ухаанаар сүм хийдийн талаар нэрийг дурдах, очсон сүм хийдийн шүтээн, дурсгалт газрын талаар илүү өгүүлсэн байдаг.

Монголын орчин үеийн уран зохиолд энэ чиглэлийн бүтээлүүд ч түгээмэл байдаг. 1930-д оноос манай уран зохиолд замын тэмдэглэл нилээд элбэг бичигдсэн байна.

Д. Нацагдоржийн (Содном, 1966; Яцковская, 1974) “Улаанбаатараас Берлин хүртэл” (1927), Ц. Дамдинсүрэнгийн “Японы тухай тэмдэглэл” (1957), Б. Ринчений “Өмнө этгээд зорчсон тэмдэглэл” (1958), “Баруун этгээд зорчсон тэмдэглэл” (1959) зэрэг нь зам явхын уран зохиолын төрөлд хамаарах яруу сайхан хэлээр бичигдсэн зохиолууд юм.

1950-ад оноос эхлэн зам явхын уран зохиол, сэтгүүл зүйн нийтлэл уран сайхны бичлэгийн бие даасан томоохон зүйл болж төлөвшсөн бөгөөд энэ бичлэгийн төрлөөр дагнан бичдэг зохиолч, сэтгүүлчдийн тоо ч нэмэгджээ. Ахмад сэтгүүлч Г. Дэлэгийн “Хал үзсэн буурал хот”, “Лаост хийсэн тэмдэглэл”, “Номин цэнхэр эрэг” (1974) Л. Түдэвийн (Лочин, 2002) “Болгар нутагт” (1959), “Нэгэн хувьсгалын тухай сурвалжлага” (1963), “Дээр хөх тэнгэр дор бор дэлхий” (1985) “Замбуулангийн наран дор” (1978), номонд орсон тэмдэглэлүүд, “Нью-Йорк урт чацтай хот” (1987), “Барын таван тамир” (1992), Ч. Галсангын “Алаг хорвоогийн гэрэл сүүдэр” (1992) зэрэг тэмдэглэлүүд шилдэг бүтээл болж ХХ зуунд хөгжсөн зам явахын уран зохиолын содон жишээ болж үлдсэн байна.

Ноён хутагт Данзанравжаагийн “Тавдугаар ноён гэгээнтний цэдгийн товч хураангуй оршив” хэмээх нэгэн зүйл товч намтар байдаг. Энэ зохиолд: Жанжаа очирдарын гэгээнээ бараа болж У Тай Шан орноо мөргөөд тэндэх засаг ханаас Нархажидын авшиг хүртэв. Мөн Утайн газраа чилээрхэж байхад Богд минь (Жанжаа гэгээн) намайг “Ар монгол газраа гарваас сайн болмуй” хэмээсэн ёсоор, хотын хойт Ширээт гэгээний нутагт ирж чилээ амирлаж, “Саруул тунгалаг” хэмээх дууг эхэлж, дараагаар олон зүйл эгшиг сургаал тэргүүтнийг олонтаа зохиов. Нохой жилийн (1826) өвөл Бээжингийн газар хүрээд, Очирдара, (Жанжаа гэгээн) нартаа мөргөн бараалхаж номын рашааныг хүртэж байх үесэд, Их гэгээнтнээс (Жанжаа гэгээн) “Энэ өвөл нутагтаа буцтугай, Гахай жилийн (1827) гуравдугаар сарын арван таванд Бүтээлчин эрхт Лондол Ринбүчи Шамбалд хаан суумуй. Тэр үесэд Дүйнхор дацан байгуулж өөрийн шавданг өөрөө хичээгтүн” хэмээн Дэмчиггаравын жинан ба гүсүнгүгдэн хайрлав. Тэндээс зарлигчлан өөрийн нутаг буцсан ...”, “Хулгана жилийн (1828) намар Долоннуурын газар заларч Жанжаа эрдэнэдээ мөргөж номын рашаан, увидас тэргүүтнийг хүртээд Богд гэгээнтнээ (Жанжаа эрдэнэ) бараа болж, Жанчхүүгийн давааны ар хүрээд буцсан ...” мөн “...Долоннуурын шар сүмийн газраа Богд гэгээндээ (Жанжаа гэгээн) бараалхаж Ажаа гэгээнтэн Их багш Дацан ламын хамт Ямандагийн ван хүртсэн...” туулай жил (1831) онд чүсан хийдийн газраа эцэг Богд лам хамба доржчантай (Жанжаа гэгээн) учирч олон номын ван, жанан, лүн тэргүүтнийг хүртэж тэр ламын зарлигаар арга буюу буцаж, Алагшаагийн нутагт ирсэн бичин жилийн (1836) өвөл цаг Бээжинд заларч Жанжаа Очирдара Жоч багштанаа бараалхан мөргөсөн, Гахай жилийн (1839) зун цаг Долоннуурын шар сүмийн газар Жанжаа очирдарын гэгээнээ бараалхаж мөргөсөн, үхэр жилийн (1841 онд) цагаан сараар Алагшаагийн баруун хийдээс цааш явахыг завдтал бас Жанжаа гэгээнээс буцаасан хэмээн энэхүү зохиолд тэмдэглэсэн байдаг. Энэ бол монгол бичгээр монгол хэлээр бичсэн нэгэн зүйл тэмдэглэл бөгөөд намтрын дотор багтаж тэгэхдээ аян замд хаана хэрхэн юуны учир одсоныг товч тодорхой дурьдсан зүйл юм. Цаашид энэ мэтээр үргэлжлүүлж тэмдэглэсэн байдаг.

XIX зуунд Зам явахын уран зохиол нь зөвхөн монгол хэлээр төдийгүй төвөд хэлээр бичигдэж байсны нэгэн томоохон жишээ бол Агваандоржиевийн “Дэлхийг эргэн бядсан домог сонирхлын бичиг төдий хэмээх” юм. XIX зууны шашин соёлын

нэрт зүтгэлтэн Агваандоржиев нь “Дэлхийг эргэн бядсан домог сонирхлын бичиг төдий” хэмээх зохиолдоо өөрийн намтрыг монгол, төвөд хэлээр шүлэглэн бичжээ. Энэ зохиол нь Л. Хүрэлбаатарын орчуулгаар “Алтан хүрдэн” (1992), “Сайн үгсийн сан” I боть (1995) зэрэг ном сурах бичгүүдэд хэвлэгдсэн байна.

“Агваан лхаарамба”, “Бандид хамбо”, “Цаншав Дорж” хэмээх нэрээр алдаршсан Агваандоржиев Буриадын бурхан шашны тэргүүн байсан ба төвөд монгол хэлээр гүн ухаан, яруу найраг, хэл шинжлэлийн хэд хэдэн бүтээл туурвисны дотор гол бүтээл нь “Бодьсадын явдалд орохуй хэмээхийн тайлбар хувь заяа сайнт”, “Дэлхийг эргэн бядсан домог сонирхлын бичиг төдий” хэмээх бүтээлүүдээ төвөд монгол хэлээр бичжээ. Мөн тэрбээр 1905 онд нэгэн зүйл монгол үсэг зохиосон нь “Вагиндрагийн үсэг” хэмээн алдаршжээ. Вагиндрагийн үсэг хэмээсэн нь Агваандоржиев өөрийн төвөд нэр Агваан гэдэг үгийг самгардаар орчуулан Вагиндра хэмээн нэрлэсэн хэрэг юм.

“Дэлхийг эргэн бядсан домог сонирхлын бичиг төдий” хэмээх зохиолоо шүлэглэсэн хэлбэрээр бичсэн бөгөөд энэ зохиолдоо Агваандоржиев төрсөн цагаасаа эхлэн Төвөд рүү явж ном эрдэм сурсан хийгээд XIII далай ламын дэргэд байж Төвөд, Орос хоёрын хооронд зуучилсан ба Төвөдийг тусгаар улс болоход оролцож Монголтой гэрээ хэлэлцээр хийж байсан тухайгаа өгүүлсэн байна. Энэхүү “Дэлхийг эргэн бядсан домог сонирхлын бичиг төдий” хэмээх шүлэглэсэн зохиолдоо:

Агваандоржиев нь XV жарны Хөх бар жил буюу 1854 онд Буриадын хорийн Хар шивэргэд гэдэг газар эцэг Дорж, эх Длгор нарын гэрт мэндэлжээ. 18 нас хүртлээ эгэл хүний амьдралаар амьдарч байсан ба 14 насандаа Ар Богдын хүрээний дэд хамбаас увашийн санваарийг¹ аваад 15 насандаа аврал хамба Ванчингаас аюушийн цэван хүртсэн байна. 19 насандаа Брайбун хийдэд орсон боловч тэр үед Төвөдүүд Оросуудыг тэрс үзэлтэн хэмээн хөөж байсан учраас ар богдын хүрээ рүү буцаж гэлэнгийн санваар авсан байна. Агваандоржиев шүлэглэсэн нь

Амьтны итгэл Далай ламын гэгээнтэн

Арван гурван сүүдэр зооглож

Алгасалгүй цанидийн сургуулийг

Айлдах нөхдөд багтаж

Арван жилд тасралтгүй бараа болбой (Хүрэлбаатар, 1992: 107) гэсэн нь Агваандоржиев Далай ламын туслахаар арваад жил ойр дотно байсан ба Далай ламын хамгийн ойрын улс төрийн зөвлөх байжээ.

Орос Англи хоёрын газар ба

Онц эзэрхсэн төр нь

Огт тусгаар байх ёсыг

Олон мэдэгчдэд дахин дахин мэдүүлээд

Энэ хоёр хаан гүрэн нь

Эв үгүй байдаг дээрээс

Эдүгээ Төвдийг Англи бээр

Эзлэх хэмээн сэдэхүйд

Эрхбиш Оросууд Төвдэд тусалмуй хэмээн

¹Увашийн санваар - бусдыг хорлохын уг суурь лугаа сэлтийг тэвчиж цалгайрсан ёс цаазын үргэлжлэлийг боон хаах бодь мөрийн замд орох

Эрхэмлэн мэдүүлэхэд одоо анхаарвай гэсэн байдаг нь Англи улс Төвөдийг эзлэхээр элдэв арга чарга хэрэглэж байх тэр үед далай лам болон Төвөдийн эрх баригчдад Орос Төвөдөд тусалж чадах тухай удаа дараа айлтгаж байжээ. Агваандоржиевийг Төвөдийн эрх баригчид Хятад Орос болон Франц улстай танилцуулах тэдгээр орныг Төвөдөд хэрхэн ханддагийг тодруулах даалгавар өгч эдгээр орнуудад илгээсэн байна. Энэтхэг Хятад, Монголоор дамжин Орост очиж өөрийн төрсөн нутаг болох Өвөр Байгальд хүрэлцэн иржээ. Өвөр байгальд байх үед Оросын нийслэлд ирэхийг Эспер Уктомский ван хэл өгүүлсэн байна. Тийнхүү Агваандоржиев 1898 оны 12 сард Санкт Петербургт ирж эзэн хаанд анх удаа бараалхжээ.

Буриадуудын дунд нэр хүндтэй бурхны шашинд элэгтэй Уктомский ван үүнийг санаачлан зохион байгуулж Төвөдийн Далай лам Агваандоржиеваар Орос улсад элэгтэй ба найрсагаар хандаж гадны улстай хаалттай байдгийг дамжуулсан нь Оросын Николай хаанд таалагдсангүй. Хэдий тийм боловч Оросын эзэн хаан болон Далай ламын бие төлөөлөгчийн хооронд болсон анхны уулзалт гэдэг утгаараа Орос Төвөдийн шууд яриа хэлэлцээний үүдийг нээж өгсөн байна (Батбаяр, 2009).

Түүний дараа Агваандоржиев Европын орнуудаар явахын өмнө Халимагийн нутагт зочилж бурхан шашныг сэргээн дэлгэрүүлж байжээ. Тэгж явахдаа Дөрвөд аймгийн убаш Орчоновтой танилцсан байна. Төвөдийг Английн гарт оруулахгүй тухай Оростой хэлэлцсэн бичиг айлтгал бичиж бэлэг сэлтийн хамт Убаш Орчоновт өгч Лхас руу явуулжээ. Өөрөө тэр завсар Далай ламын зааврын дагуу Европын орнууд болох Франц, Англи, Итали, Австри орж Парис, Лондон, Ром, Наполи хотуудаар аялсан бөгөөд энэ тухайгаа замын тэмдэглэлдээ дурьдсан байна. Европын орнуудаар явж ирээд Ижил мөрний Халимагуудаас мал эдийн дээж өргөлүүдийг авч зайсан убаш Орчоновын хамт Халимагаас гарч дээд Үдээр дамжин Их хүрээнд очиж Жавзундамба багш Ёнзон багшийн ивээлд сар орчим суусан байна. Тэндээс убаш Орчонов Лхасыг зорин Агваандоржиевийн бэлэг сэлт захиаг аван Лхас руу хөдлөв. Убаш Орчонов Лхаст очиж Далай ламд мөргөөд түүний хариу захидлыг авч Их хүрээнд 1899 онд очиж тэнд хүлээж байсан Агваандоржиевд хүргэж өгчээ.

Төвөдийн дотоод байдал төвөгтэй эрх баригчдын санал хэд хэд хуваагдсан байдалтай байгааг дурдаад Агваандоржиевийг өөрийн биеэр Лхаст ирж төрийн хэргийг хэлэлцэхийг хүссэн байна. Агваандоржиев 1899 оны сүүлчээр Лхаст хүрч 1900 оны 2 сард болсон цагаан сарын Монлам Чэнмо хурлын үеэр Далай ламд эртний зүйлүүд ба зуун цагаан ембүү жагар торго сэлт зэрэг өргөл барьцыг барьсан байна.

Төвөдийн эрх баригчид Манжийн хаанаас салж болохгүй гэж нэг хэсэг нь, нөгөө хэсэг нь Англитай эв найрамдалтай байя гэсэн саналтай, зарим нь Орос орныг түших хэрэгтэй гэсэн 3 өөр саналтай байсан тухай замын тэмдэглэлдээ өгүүлсэн байна. Тэрбээр цааш нь шүлэглэсэн намтартаа:

Хувь төгөлдөр лам Шаравжамц бээр дааж аваад баймуй

Тэнд увашийн мөрийг залгаад

Тэвдэж Шанхайд хүрэхэд

Тэнгэрээс эштэй хэмээх

Тэнэг Ихэгуань цэрэг хөдөлж

Хэрэмтэй Хятад ба Европуудыг

Хэтэрхий алснаар Европын

Хэдэн хаад цэрэг авчирч

Гэсгээн дайралцах цаг тааралдаж
Шанхайгаас Японы Нагасакад (1900)
Шадарлан хүрээд хэдэн хоногт
Японы онгоц хүлээн хамт
Яваад Владивосток хүрвэй
Амар мөрнийг онгоцоор өгсөхөд
Айгунь хотыг хоосортол түймэрдсэн нь
Араатан мэт аймшигтай үзэгднэм
Аян замаар явсаар

Агу-гийн намдагтай нөхцөж...гэсэн нь Далай лам хоёр дахь удаагаа Агваандоржиевийг Орос руу явуулж Оросын эзэн хааны үгийг сонсож ирэхийг даалгасан байна. Тэрбээр 2 дахь удаагаа явахдаа маш хүнд бэрх замыг туулсан бөгөөд Хятадаар дайрч явсан боловч Хятадад Ихэгуаний бослого гарч байсан учраас Шанхайгаас Нагаски боомтоор дайран Владивосток хүрчээ.

Далай лам Оросын эзэн хаан Николайд илгээсэн захидалдаа “Умард зүгийн хүмүүн ард хэрхэн бурханд шүтэж, энэ болон ирэх насандаа буян үйлдэж буйг лавлан мэдэхээр цанид хамбо Агваандоржиевийг илгээснийг айлтгаад их эзэн хаан та үүнийг таатай үгээр угтаж түүнчлэн олон түмэн албат ардаа тэдний шашин шүтлэгт тааруулан амар жимэр захиран сууж, ялангуяа халимаг болон Буриад олныг халамжлан хайрлаж буйг” түүнээс сонсод ихэд байрлаж байгааг илэрхийлжээ. Агваандоржиев хоёр дахь удаагаа Орост удсангүй эзэн хааны хариу бичгийг аваад Их хүрээгээр дайран Говийг туулж хуурай замаар явж 72 хоногийн дараа Лхаст ирсэн байна.

Энэ тухай бичихдээ
Хар далайн зах хүрч
Хаан Николайд Министр лүгээ учраад
Хариас бариулсан бэлэг бариад
Хариу үнэ төгөлдөр бэлэг авч
Хурдан хүрэхээр шууд яваад
Да Хүрээнээс гараад
Далан хоёр хоноод Лхас хүрвэй...

Далай лам Оросын эзэн хаан Николайд Орос болон Төвөдүүд эв найрамдалтай байхыг үнэнхүү хүсэж байгааг илэрхийлсэн боловч түүнд эзэн хаан тодорхой хариу өгөөгүй бөгөөд Оросын найрамдалт харилцааг олох аваас Төвөдийн цаашдын хувь заяанд ямар нэг хохирол учрахгүй хэмээн ерөнхий үгээр аргадан өнгөрөөжээ. Агваандоржиевийг Төвөдөд эргэж ирэхэд Англи Төвөд рүү дайрчээ. Төвөдүүд эсэргүүцэл үзүүлсэн боловч үй олноор устгажээ. 1904 онд Төвөдийн Лхасыг эзэлсэн байна. Энэ тухайгаа шүлэглэн

Арын Орос, Япон лугаа цэрэгдэж
Алмайран чөлөөгүй цагт нь
Англи Төвдийн захад цэрэг оруулбай (1904)
Аху олон орныг эс үзэгчид
Амархан цэрэглээд буцаамуй хэмээн
Аяа энэ Английн хүчин нь
Аймшигтай их тул яахан тэсмүй та
Аргаар эвдэрснээс сайн буюу хэмээн

Ахлагч заримуудад шамдлаар хэлэхүйд
 Ойшоохгүй цэрэглэхийн дээр
 Уймар намайг Англитай нэгдмүй хэмээмүй
 Удалгүй Англи ирвээс
 Одоо намайг барьж авмуй хэмэнэ.
 Онц бөглүү бэрхээр дутааюу хэмээн
 Унаа луусыг бэлдээд мөнгөн зоос хийх
 Усан тээрэм хийлгэж суувай^{1/4}(Хүрэлбаатар, 1992: 116).

Далай лам Их хүрээнд ирэхэд Богд Жавзундамба хутагт угтаж аваагүй байна. Далай ламд хүндэтгэл үзүүлэхгүй байхыг Богдод тушаасан ба Манж амбанаар нүд цавчилгүй харуулж байжээ.

Хэдийгээр Далай лам, Богд Жавзундамба хоёр өнгөн дээрээ зөрчилдөөнтэй мэт боловч нууцаар хоёр удаа уулзаж Төвөд болоод Монгол, Манжийн эрхшээлээс гарч тусгаар улс болно хэмээн гэрээ хийж байжээ. Далай лам болон Агваандоржиев Бээжинд очиж Манжийн хаан Гуаньской болон хатан Цыси нарт бараалхах гэсэн боловч хаан болон хатны бие муу байсан учраас тэднийг хүлээж авч чадаагүй байна. Далай лам 1908 оны 12 сард Бээжингээс морджээ. 1912 онд төвдүүд бослого гаргаж Лхас хотод байсан хятадуудыг үлдэн хөөсөн ба энэ бослого нь зүүн Төвдийг хамарч Литан, Батан, Чимдод байсан Хятадуудыг хөөв. Далай лам 1913 оны 1 сард Лхас дахь өөрийн Бодаалингийн ордонд заларснаар Төвдийн тусгаар тогтнолын шинэ эрин эхэлсэн байна (Батбаяр, 2009).

Далай лам Агваандоржиевийг Их хүрээ явуулж гэрээ хэлэлцээр хийсэн байна. Энэ тухайгаа шүлэглэн бичихдээ.

Хатуу бэрх Сиртан давж
 Халх хүрээнд хүрээд
 Хамгийг айлдагч эзэн богд Жавзундамбад
 Хайрласан бэлэг сэлтийг өгвэй
 Төвд Монгол хоёулаа
 Тэргүүнээс эв найрамдалтай тул
 Тэр учраа хойшид ч
 Тэмдэгт гэрээгээр эв баталбай бид [Хүрэлбаатар, 1992: 121]

Жавзундамба хутагтыг Монголын шашин төрийг хослон баригч хаанд өргөмжилж Далай ламыг Төвөдийн шашин төрийг хослон баригч хаанд өргөмжилсөн байна. Ийнхүү Монгол, Төвөд хоёр улс өөрсдийгөө шашин төрийг хослон баригч хаант засаглалтай хэмээн хүлээн зөвшөөрч хоёр улс гэрээ байгуулсан тухай энд өгүүлж байдаг нь уг тэмдэглэлийн бас нэг ач холбогдол юм.

Агваандоржиев шүлэглэсэн тэмдэглэлийнхээ төгсгөлд
 Хорин найман насыг хүртэл тэнэсэн явдлыг
 Аль мууг нуугаад сайныг түүж
 Ичгүүргүй өвгөн Вагиндра хэмээх бээр

Төмөр тахиа жилийн гутгаар сард бичвэй хэмээн хаагуур хаагуур явж юу хийсэн тухайгаа өгүүлсэн байдаг.

Эндээс үзвэл монголын бичгийн уран зохиолын түүхэнд дундад зууны үеэс аян Зам явахын уран зохиол уламжлагдан ирсэн байна. Цахар гэвш Лувсанчүлтэм, Хөх нуурын Ишбалжир, Өндөр гэгээн Занабазар нарын бүтээлчид аян Зам явахын уран

зохиолгэж нэрлээгүй боловч намтар зохиол сэлтэд нь номын орон хүрээ хийдээр хаана хаана очиж юу үзэж, ямар ёслол хурал ном үйлдэж байсан зэргээ дэлгэрэнгүй өгүүлсэн зүйл нилээд байна. Харин Данзанравжаагийн товч намтрыг бол үндсэндээ дөч орчим хувийг нь замд явсан тэмдэглэл эзэлж байна. Эдгээрээс бурхны шашны нэрт зүтгэлтэн Агваандоржиевийн “Дэлхийг эргэн бядсан домог сонирхлын бичиг төдий” гэдэг зохиол бол бие даасан аян замын тэмдэглэл, даруй зам явахын уран зохиол юм. Бусад тэмдэглэлүүд үргэлжилсэн үгээр байгаа бол Агваандоржиевийн энэ зохиол шүлэглэсэн хэлбэрээр бичигдсэн байна.

Эндээс үзвэл монголын эртний уран зохиолд дундад зууны үеэс төвөд монгол хэлээр аян замын тэмдэглэлүүд бичигдэж ирсэн нь тэр үеийн гол төлөөлөгчдийн бүтээлээс тодорхой харагдаж байна. Ингэхдээ төвөд монгол хэлээр бичигдэж байсан баримтууд байгаагаас гадна, мөн үргэлжилсэн үг болон шүлэглэсэн хэлбэрээр бичигдсэн бүтээлүүд байна. Мөн бүхэлдээ аян Зам явахын уран зохиолзохиол байхаас гадна, тодорхой өөр зүйлийн зохиол дотор аян замын тэмдэглэлийн элементийг хадгалсан хэсэг бүлэг тэмдэглэл ч уламжлагдаж ирсэн нь энэ төрлийн зохиолын нэг онцлог болж байна.

ГУРАВ. МОНГОЛЫН ЭРТНИЙ УРАН ЗОХИОЛ ДАХЬ ЗАМ ЯВАХЫН УРАН ЗОХИОЛЫН ТУУРВИЛЗҮЙН ОНЦЛОГ

Монголын уран зохиолын зам явахын уран зохиолын төлөөлөгч болсон нэгэн бүтээл нь Агваандоржиевийн “Дэлхийг эргэн бядсан домог сонирхлын бичиг төдий” гэсэн зохиол болно.

Энэхүү зам явахын уран зохиол нь агуулгийн хувьд нэгэн улс орон, тодорхой газар нутгыг зорчин очхын зам зуурын учир явдал, үзсэн харсан сонин содон зүйлийг шүлэглэсэн хэлбэрээр бичиж, туурвилзүйн аргийг ашиглан тэмдэглэлийг уран зохиолын төрөл болгон хөгжүүлсэн нь тодорхой билээ.

ДҮГНЭЛТ

1. Зам явахын уран зохиолын уламжлал нь монголын түүх, соёлын чухал хэсэг болж, монголын уран зохиолын онцгой нэгэн төрөл болж баримтат уран сайхны хэлбэрээр хөгжиж ирсэн олон жишээ байна.

2. Монголын зам явахын уран зохиол нь туурвилзүйн олон арга хэрэглүүрийг ашиглаж, тухайлбал, хувь хүний туршлага, үнэн бодит түүхэн үйл явдлыг уран сайхны арга хэрэглүүрээр баяжуулан хөгжиж ирсэн байна.

于省吾 (1937). 穆天子传新证 [J], 《考古》年第1期.

顾颉刚 (1951). 穆天子传及其著作年代 [J], 《文史哲》, 年第2期.

李伯齐主编 (1989). 中国古代纪游文学史 [M], 济南山东友谊书社, 年版. 万陆著 (1989). 中国散文美学 [M], 中州古籍出版社年版

郑杰文著 (1992). 穆天子传通解 M, 济南. 山东文艺出版社, 年版.

王贻梁 (1994). 穆天子传 的史料价值 [J], 《华东师范大学学报》(哲学社会科学版), 年第6期.

郑杰文 (1996). 论 穆天子传 的认识价值 [J], 《天津师范大学学报》(社会科学版) 年第1期.

方艳著 (2015). 穆天子传 的文化阐释 [M] 北京. 中国文联出版社, 年版

崔冰洋 (2018). 穆天子传 游记特色研究, 青岛大学硕士学位论文

Н о м з ү й

Бадмаев, А. В. (1973). О жанре «хождений» (описания путешествий) калмыцкой литературы. *Ученые записки КНИИЯЛИ*. XI. Серия филология. Элиста. 33–53.

Батбаяр, Ц. (2009). *Монгол ба Төвд XX зууны эхний хагаст*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Дамдинсүрэн, Ц. (1957). *Монголын уран зохиолын тойм. I дэвтэр. XIII–XVI зууны үе*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Дамдинсүрэн, Ц. (1958). *Японы тухай тэмдэглэл*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Дамдинсүрэн, Ц. (1998). *Бүрэн зохиол*. Тайлбар сэлт ном зүй үйлдэж хэвлэлд бэлтгэсэн Д. Цэдэв. 2. Улаанбаатар: «Интерпресс» хэвлэлийн газар.

Лочин, С. (2002). *Л. Түдэв: намтар, уран бүтээл, судлалын товчоо*. Улаанбаатар: Bembi San.

Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл (1967). Editor Цэндийн Дамдинсүрэн. Translated by Ч. Алтангэрэл. Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн Хэвлэл.

Монголын орчин үеийн уран зохиолын түүх (1985). Тэргүүн боть. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Нацагдорж, Д. (1927). *Улаанбаатараас Берлин хүртэл*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Норовсүрэн, Л. (1994). *Сонин бичлэгийн төрөл зүйл*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Норовсүрэн, Л. (1996). *Монголын тогтмол хэвлэлийн бичлэгийн төрөл зүйл*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Омакаева, Э. У. (2013). Феномен личности Бааза-Багши и его паломничество в Тибет в буддийском культурном и топонимическом пространстве. *Бааза-багши и его духовное наследие* (Элиста, 01 декабря 2013 года). Элиста: Джангар. 21–31.

Ринчен, Б. (1945). Улаанбаатараас Цэцэрлэг хүртэл (замын тэмдэглэл). *«Үнэн» сонин*. 81.

Ринчен, Б. (1958). Өмнө этгээд зорчсон тэмдэглэл. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Ринчен, Б. (1959) Баруун этгээд зорчсон тэмдэглэл. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Содном, Б. (1966). Д. Нацагдоржийн намтар зохиол. Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо.

Сүглэгмаа, Х. (2005). Монголын уран зохиол дахь “үг” зохиолын төрөл зүйл. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Түдэв, Л. (1958). *Болгар нутагт*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Түдэв, Л. (1963). *Нэгэн хувьсгалын сурвалжлага*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Түдэв, Л. (1978). *Замбуулангийн наран дор*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Түдэв, Л. (1998). *Дээр хөх тэнгэр дор бор дэлхий*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Хүрэлбаатар, Л. (1989). *Сонгодог уламжлал монгол яруу найраг*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Хүрэлбаатар, Л. (1992). *Алтан хүрдэн*. Монгол зохиолчдын түвэд хэлээр туурвисан бүтээлийн цомирлог. Улаанбаатар: Шувуун саарал хэвлэх үйлдвэр.

Хүрэлбаатар, Л. (2006). *Аварга могойн зулайн чандмань*. Улаанбаатар: Admon.

Хүрэлбаатар, Л. (2009). *Дорно цаст*. Улаанбаатар: Admon.

- Цендина, А. Д. (2022). «Устная история» в дневниках Ц. Дамдинсүрэна. *Oriental Studies*. 15. 5. 1147–1158.
- Цэвэгмид, Д. (2005). *Эргэн санахад. Дурсамж, тэмдэглэл*. Улаанбаатар.
- Яцковская, К.Н. (1974). *Дашидоржийн Нацагдорж. Жизнь и творчество*. Москва: Наука.
- Cui Bingyang (2018). *Research on the Characteristics of Travel Notes in Mu Tianzi Zhuan*. Master's Degree Thesis, Qingdao University.
- Zheng, Jiewen (ed.) (2011). *Mo xue dui Zhongguo she hui fa zhan de ying xiang*. Jinan: Shandong ren min chu ban she.

References

- Badmaev, A. V. (1973). On the genre of “travel” (journey descriptions) in Kalmyk literature. *Scholarly notes of the KNIYALI*. XI. Series of philology. Elista. 33–53.
- Batbayar, Ts. (2009). *Mongolia and Tibet in the first half of the XX century*. Ulaanbaatar: State Publishing House.
- Cui Bingyang (2018). *Research on the Characteristics of Travel Notes in Mu Tianzi Zhuan*. Master's Degree Thesis, Qingdao University.
- Damdinsuren, Ts. (1957). *Review of Mongolian literature*. Book I. XIII–XVI centuries. Ulaanbaatar: State Publishing House.
- Damdinsuren, Ts. (1958). *Notes on Japan*. Ulaanbaatar: State Publishing House.
- Damdinsuren, Ts. (1998). *Complete works*. Annotated bibliography prepared for publication by D. Tsedev. 2. Ulaanbaatar: Interpress Publishing House.
- History of modern Mongolian literature* (1985). Volume 1. Ulaanbaatar: State Publishing House.
- Khurelbaatar, L. (1992). *Golden Ring*. A Collection of Works by Mongolian Writers in the Tibetan Language. Ulaanbaatar: Shuvuun Gray Publishing House.
- Khurelbaatar, L. (2006). *The Summer Chandman of the Giant Snake*. Ulaanbaatar: Admon.
- Khurelbaatar, L. (2009). *Eastern Snow*. Ulaanbaatar: Admon. Khurelbaatar, L. (1989). *Classical Tradition of Mongolian Poetry*. Ulaanbaatar: State Publishing House.
- Lochin, S. (2002). *L. Tudev: biography, works, research bureau*. Ulaanbaatar: Bembi San.
- Natsagdorj, D. (1927). *From Ulaanbaatar to Berlin*. Ulaanbaatar: State Publishing House.
- Norovsuren, L. (1994). *Types of newspaper articles*. Ulaanbaatar: State Publishing House.
- Norovsuren, L. (1996). *Types of Mongolian periodical articles*. Ulaanbaatar: State Publishing House.
- Omakaeva, E. U. (2013). The phenomenon of Baaza-Bagshi and his pilgrimage to Tibet in the Buddhist cultural and toponymic space. *Baaza-Bagshi and his spiritual heritage* (Elista, December 1, 2013). Elista: Dzhangar. 21–31.
- Rinchen, B. (1945). *From Ulaanbaatar to Tsetserleg* (travel notes). «Unen» newspaper. 81.
- Rinchen, B. (1958). *Notes from a journey to the east*. Ulaanbaatar: State Publishing House.
- Rinchen, B. (1959). *Notes from a journey to the west*. Ulaanbaatar: State Publishing House.
- Sodnom, B. (1966). *Biography of D. Natsagdorj*. Ulaanbaatar: State Publishing House Committee.
- Suglegmaa, H. (2005). *Genres of “word” prose in Mongolian literature*. Ulaanbaatar: Monkhin Shup.
- Tsendina, A. D. (2022). «Oral History» in the Diary of Ts. Damdinsuren. *Oriental Studies*. 15. 5. 1147–1158.
- Tsevegmid, D. (2005). *In retrospect. Memoirs and notes*. Ulaanbaatar.
- Tudev, L. (1958). *In the Bulgarian Land*. Ulaanbaatar: State Publishing House.



Tudev, L. (1963). *Report of a Revolution*. Ulaanbaatar: State Publishing House.

Tudev, L. (1978). *Under the Sun of Zambuulang*. Ulaanbaatar: State Publishing House.

Tudev, L. (1998). *Above the Blue Sky, Under the Brown Earth*. Ulaanbaatar: State Publishing House.

Yatskovskaya, K.N. (1974). *Natsagdorj of Dashdorji. Life and creativity*. Moscow: Nauka.

Works written in Tibetan by Mongolian writers (1967). Editor Tsendin Damdinsuren. Translated by Ch. Altangerel. Ulaanbaatar: Academy of Sciences Press.

Zheng, Jiewen (ed.) (2011). *Mo xue dui Zhongguo she hui fa zhan de ying xiang*. Jinan: Shandong ren min chu ban she.